5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдсан зардал)	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн нийт санхүүжилт: /71.64 сая ам.доллар/</li> <li>Азийн хөгжлийн банкны санхүүжилт: /45.0 сая ам доллар/</li> <li>МУЗГ-ын хөрөнгө оруулалт: /26,64 сая ам.доллар/</li> </ul>				
		Үүнд:	Нийт төсөв	Гүйцэтгэл /2016 оны 4 дүгээр улирлын байдлаар/	Гүйцэтгэл /2017 оны жилийн эцсийн байдлаар/	Гүйцэтгэл /2017 оны жилийн эцсийн байдлаар/	Хувь
		Барилгын ажлын санхүүжилт:	МУЗГ-ын батлагдсан төсөв Улсын төсвөөс 16,335,000,000 /төгрөг/	11,665,950,430 /төгрөг/	3,125,100,000 /төгрөг/	14,791,050 430,000 /төгрөг/	90.55%
		Төслийн үйл ажиллагааны зардал:	АХБ-ны буцалтгүй тусламж 1,379,167.94 /сая ам.доллар/	971,916.42 /ам. доллар/	183,460.12 /ам.доллар/	1,155,376.54 /сая. ам.доллар/	78.52%
		Зөвлөх үйлчилгээний зардал:	АХБ-ны буцалтгүй тусламжаас 1,355,540 /сая ам.доллар/	236,751.27 /ам. доллар/	160,426.59 /ам.доллар/	397,177.86 /ам.доллар/	29.30%
Ложистикийн төвийн барилга	АХБ-ны зээлээс 32,400,313.00 /сая ам.доллар/	4,963,053.30 /сая ам доллар/	10,988,436.50 /сая ам.доллар/	15 951 489,80 /сая ам.доллар/	49.23%		

		угсралтын болон төмөр замын холбоо дохиоллын ажилд					
		Төслийн зорилт					
6	1-р зорилтын хүрээнд: Худалдаа, тээвэр, Логистикийн үйлчилгээг хөнгөвчлөх, Олон улсын транзит тээврийг дэмжих, Хил, гааль, мэргэжлийн хяналтыг хөнгөвчлөх, үр нөлөөг сайжруулах, <u>Хүрэхүрдүн</u> : М онгол улсын импорт, экспорт, дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдэж дотоодын болон бүс нутгийн тээврийн эргэлт хурдсах, гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудын ажлын нөхцөл сайжрах, хяналт чанаржих, гаалийн байгууллагын хүчин чадал нэмэгдэх юм.		<ol style="list-style-type: none"> <li>1. Тус төслийн хүрээнд баригдах ложистикийн төвийн цогцолбор нь олон улсын транзит тээврийг дэмжих зориулалттай ба ложистикийн төвд авто машинаас галт тэрэг, галт тэрэгнээс авто машин, галт тэрэгнээс галт тэрэг рүү ачаа ачиж, буулгах мөн гаалийн баталгаат агуулах баригдаж, гааль, мэргэжлийн хяналтын нэгдсэн үйлчилгээг энд бий болгох юм.</li> <li>2. Ложистикийн төвийн барилга угсралтын ажил тодорхой үе шаттай хэрэгжиж ирсэн бөгөөд одоогийн байдлаар ложистикийн төвийн үйл ажиллагаанд 14,791,050,430.000 төгрөгийн төсөвт өртөг бүхий 1) Ложистикийн төвийг хангах эрчим хүчний шугам, дэд станцын барилга байгууламжийн ажил, 2) 3,6 км цэвэр усны шугамын ажил, 3) Төмөр замтай 2 түвшинд огтлолцох гүүрэн байгууламж, 1,6 км авто замын барилга угсралтын ажил, 4) 15 км гадна холбоо интернетийн шилэн кабель суурилуулах ажил, 5) Логистикийн төвийн гадна цахилгаан /110 кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, Логистикийн төвийн дэд станцын өргөтгөл/ хангамжийн зураг төсөл боловсруулах ажил, 6) Логистикийн төвийн гадна цахилгаан /110 кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, Логистикийн төвийн дэд станцын өргөтгөл/ хангамжийн барилга угсралтын ажил 7) Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, 8) Ложистикийн төвийн гадна хамгаалалтын хашааны ажил, 9) Зураг төсөлд магадлал хийх зэрэг ажлуудыг дотоодын гүйцэтгэгч 9 компани хийж гүйцэтгээд байна.</li> <li>3. Ложистикийн төвийн төмөр замын дохиолол холбооны байгууламжид релейн цахилгаан төвлөрүүлэлтийг суурилуулахаас татгалзаж, микропроцессорын цахилгаан төвлөрүүлэлтийн системийг суурилуулахаар шийдсэн тул дохиолол холбооны зураг төслийн ажлыг шинэчилж хийлгэхээр болсны дагуу Төмөр замын дохиолол холбооны зураг төсөл болон угсралтын ажлыг цогцоор нь гүйцэтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах тендерийн бичиг баримтыг шинэчлэн боловсруулж УБТЗ болон ЗТХЯ, АХБ-наас өгсөн саналуудыг тусган 2017 оны 8 дугаар сарын 24-ний өдөр АХБ-наас зөвшөөрлийг авсан.</li> <li>4. 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр төмөр замын дохиолол холбооны зураг төсөл болон угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн зарыг өдөр тутмын хэвлэл, АХБ, ЗТХЯ-ны цахим хуудсуудад байршуулж тендерийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр нээсэн бөгөөд одоо үнэлэх ажил явагдаж байна.</li> <li>5. Улсын төсвийн хөрөнгөөр ложистикийн төвд шаардлагатай 2 ширхэг вандан краны нийлүүлэлт, угсралт, туршилтын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Тендерт “Хэнань Дафан Хүнд Машин механизм” компани шалгарч ЗТХЯ-тай 2017,5,12-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулж гэрээний дагуу ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 71%-тай байгаа бөгөөд үйлдвэрлэгдэж</li> </ol>				

			<p>дууссан 50 тн даацтай 1 вандан краны эд анги тоног төхөөрөмж Замын-Үүд суманд төслийн талбайдээр ирээд байна. Үүнтэй холбогдуулж 71%-ийнсанхүүжилт хийгдээд байна.</p> <p>6. Тус барилгын ажлын гүйцэтгэгчээр “China Railway 21<sup>st</sup> Bureau Group” компани ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажил 75,24%-тай хийгдэж байна.</p> <p>7. Мөн тус барилга угсралтын ажилд хяналт тавих зөвлөх компаниар Сусонг Инженеринг” компани ажиллаж байна.</p> <p>8. ТХН-ээс төмөр замын өргөн болон нарийн царигийн трассын газар эзэмших гэрчилгээний хугацааг сунгуулахаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын газрын албатай хамтран ажиллаж байна. Мөн ТХН-ээс Дорноговь аймгийн Замын-Үүд сумын газрын албатай хамтарч ажилласны дүнд дараах 8 газар эзэмших гэрчилгээг ЗТХЯ-ны нэр дээр гаргуулан авч газар эзэмших гэрээг байгуулсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Холбооны шилэн кабелийн 4,15 км трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342915;</li> <li>- 110 кВ-ын ЦДАШ-ын 4,22 км трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342920;</li> <li>- Эрчим хүчний дэд өртөөний зориулалтаар ашиглах 4200 м2 газар гэрчилгээний дугаар 000342921;</li> <li>- Өргөн царигийн төмөр замын 2,4 км трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342916;</li> <li>- Нарийн царигийн төмөр замын 0,6 км трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342917;</li> <li>- Цэвэр ус дамжуулах 3.5 км шугамын трассын дагуу газар гэрчилгээний 000342823;</li> <li>- Цахилгаан дамжуулах 35/0,4 кВ-ын 3 км шугамын трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342824;</li> <li>- 1,6 км авто зам гүүрийн трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342820;</li> <li>- Мөн гэрээний хугацаа дууссан хэд хэдэн газруудын хугацааг сунгасан.</li> </ul> <p>9. Төслийн хүрээнд баригдаж буй ложистикийн төвийн төмөр замын дэд бүтцийг барих ажлын зөвшөөрлийг 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдөр 1 жилийн хугацаатайгаар сунгуулав.</p> <p>10. Ложистикийн төвийн доторх барилга байгууламжийн зураг төсөлд ГЕГ-ын холбогдох албан тушаалтнуудаас санал авч Гаалийн барилга байгууламж хяналтын талбайг зураг төсөлд тусгасан болно.</p> <p>11. Хилийн боомт орчим газарт үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг Хил хамгаалах ерөнхий газраас гаргуулж ажилласан.</p> <p>12. Төслийн үйл ажиллагааны явцын тайланг сар, жил, улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар тогтмол гаргаж, тогтсон хугацаанд ЗТХЯ, АХБ-нд хүргүүлж ажиллаа.</p> <p>13. Төслийн гүйцэтгэгч компаниуд болон ТХН-ийн 2017 онд хийсэн ажлын гэрээ дүгнэх хурал 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр боллоо.</p>	
--	--	--	--	--

	<p>2-р зорилтын хүрээнд: Үндэсний зам, тээврийн сүлжээг өргөжүүлэх, олон улсын тээврийн системтэй холбох,  <u>Хүрэхүрдүн:</u> Логистикийн төв нь тус төслийн хүрээнд баригдах авто замаар Замын-Үүд-Улаанбаатар чиглэлийн авто зам буюу Азийн босоо тэнхлэгийн АН-3 корридортой холбогдоно.</p>	<p>14. Ложистикийн төвийг Азийн босоо тэнхлэгийн АН-3 коридортой холбох авто зам, гүүрийн ажил 100% хийгдэж дууссан.</p> <p>15. Ложистикийн төвийн төмөр замын зураг төслийг шинэчлэн сайжруулсан бөгөөд Төслийн хүрээнд баригдах 11,5 км урттай өргөн болон нарийн царигийн салбар төмөр зам барих ажлын явц амжилттай хэрэгжиж байна. Өнөөдрийн байдлаар ажлын явц 85%-тай байна. Энэ замыг барьснаар Хятад улсаас нарийн царигийн төмөр замаар орж ирсэн ачааг Улаанбаатар төмөр замын өргөн царигийн төмөр зам руу шилжүүлэн ачих, мөн өргөн болон нарийн царигийн төмөр замаас авто зам руу, авто замаас буцаагаад төмөр зам руу шилжүүлэн ачих боломж бүрдэж байгаа юм.</p> <p>16. Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс орон нутгийн холбогдох газруудтай нягт хамтран ажиллаж ирсэн бөгөөд Дорноговь аймгийн Засаг дарга, Замын-Үүд сумын Засаг дарга нартай 5-6 удаа уулзалт зохион байгуулж төслийн хэрэгжилтэд орон нутгийн зүгээс дэмжлэг авах талаар ярилцсан.</p>	
	<p>3-р зорилтын хүрээнд:  Худалдаа, тээвэр, Логистикийн үйлчилгээг хөнгөвчлөхөд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг нэвтрүүлэх,  <u>Хүрэх үр дүн:</u> Төслийн хүрээнд баригдах ложистикийн төвийн үйл ажиллагаа нь сүүлийн үеийн программ хангамжаар зохицуулагдах боломж бүрдэх юм.</p>	<p>17. Ложистикийн төвийн гадна холбоо интернетийн шугамын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан бөгөөд шалгарсан “Лийд линк” ХХК-тай 2014,9,2-ны өдөр ЗТЯ-наас ажил гүйцэтгэх гэрээг байгуулж гэрээт хугацаанд ажил 100% хийгдэж дууссан.</p> <p>18. Ложистикийн төвд АХБ-ны зээлээр санхүүжигдэх төмөр замын дохиолол холбооны зураг төсөл болон угсралтын ажлыг цогцоор нь гүйцэтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах тендерийг 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр өдөр тутмын хэвлэл болон АХБ, ЗТХЯ-ны цахим хуудсуудад байршуулан зарласан бөгөөд 11 компани тендерийн бичиг баримт худалдаж авснаас 5 компани тендэрт оролцохоор материалаа ирүүлээ. Тендерийн үнэлгээний хороо үнэлгээ хийж байна.</p> <p>19. Ложистикийн төвд суурилуулагдах диспетчерийн холбоо, чанга яригчийн холбоо, паркийн холбоо зэргийг орчин үеийн тоон технологид суурилсан холбооны хэрэгслээр тоноглохоор ажлын даалгаварт тусгагдаад байна.</p>	
7.	<p>Дүгнэлт (төслийн хэрэгжилтэд хүндрэл үүсгэж байсан болон цаашид анхаарах асуудлууд)</p>	<p><u>Төслийн хэрэгжилтэд хүндрэл үүсгэж байсан асуудлууд</u></p> <p>20. ТЭЗҮ болон ажлын зураг хангалттай түвшинд боловсруулагдаагүйгээс үүдэн ажлын тоо хэмжээнд зөрүү гарах хүндрэл үүсч байсан болно.</p> <p>21. Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн СМЕК компанийн ажлын даалгаварт зайлшгүй шаардагдах инженер техникийн болон зарим ажилтнуудыг дутуу тусгаснаас хүндрэлтэй байдал үүсч байсан.</p> <p>22. Барилгын ажлын гэрээнд өөрчлөлт оруулах асуудлаар 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэж ажилласан бөгөөд ЗТХЯ-наас 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдөр эцэслэн баталгаажигдлаа.</p> <p>23. Засгийн газрын “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай” тогтоолын төслийг 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг гаргуулж ажиллав. Мөн ТХН-ээс Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргатай хамтран ажиллаж “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах” зөвшөөрлийг гүйцэтгэгч Хятадын төмөр замын 21 товчоо</p>	

		<p>групп компаний нэр дээр гаргуулж ажиллаа. Тус ашигт малтмал буюу барилга угсралтын ажилд хэрэглэсэн хайрганы асуудлаар ТХН орон нутгийн урдирдах байгууллага, ЗТХЯ-тай байнга холбоотой ажиллаж асуудлыг шийдвэрлүүлж ажилласан юм.</p> <p>24. 2016,6 сард төслийн зөвлөх компаниар ажиллаж байсан СМЕК компанитай холбоотой төлбөрийн асуудлыг бүрэн шийдвэрлэж ЗТХЯ-тай байгуулсан гэрээ дуусгавар болсон.</p> <p>25. Замын-Үүд сумын оршин суугчдын хог хаягдлын талбайг Ложистикийн төвийн нарийн царигийн төмөр замын трасс дайран өнгөрч байгаатай холбогдуулан хогийн цэгийг цэвэрлэж, нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болсон. Иймд Замын-Үүд сумаас тавьсан хүсэлтийн дагуу АХБ-аас зөвшөөрөл авч, тус хогийн цэгийг булшилж, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардлагатай дунд оврын дугуйт экскаватор “НТЛ80”, хүнд даацгийн өөрөө буулгагч самосвал “HOWO 290” маркийн 2 машин техникийг Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газарт авч өгсний үндсэн дээр хогийн цэгийг дарж булшлах ажил хийгдсэн.</p> <p>26. Ложистикийн төвийн барилгын ажилд хэрэглэсэн ашигт малтмалын төлбөрийг төлж дууссан бөгөөд орон нутгаас тавьсан шаардлагын дагуу нөхөн сэргээх ажил хийхээр төлөвлөөд байна.</p> <p><u>Төслийн хэрэгжилтийн явцад зайлшгүй анхаарах шаардлагатай доорх асуудлууд байна. Үүнд:</u></p> <p>27. Төслийн хэрэгцээний зориулалттай 350 га газрыг Дорноговь аймгийн ИТХ-аас дуудлага худалдаанд оруулахаар төлөвлөж буйг зогсоож, ЗТХЯ-ны нэр дээр буцаан авах асуудлыг шийдвэрлэх.</p> <p>28. Төслийн гүйцэтгэгч болон зөвлөх компанийн ажиллах хүчний зөвшөөрлийг холбогдох журмын дагуу 2018 оны 1 дүгээр улиралд гаргуулан авах шаардлагатай байна.</p>			
8.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>1. ТХН-ээс Захиалагч тал болох ЗТХЯ, санхүүжүүлэгч тал болох АХБ, барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй нягт хамтарч ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Захиалагч талд төсөл хэрэгжих явцын сар улирал, хагас жил, жилийн эцсийн тайлангуудыг тогтсон хугацаанд хүргүүлсэн.</li> <li>-АХБ-нд төсөл хэрэгжүүлэх явцын үйл ажиллагааны тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэн тогтсон хугацаанд хүргүүлсэн бөгөөд АХБ-наас зохион байгуулсан уулзалт, сургалтанд хамрагдаж, ТХН-д тулгамдаж буй асуудлыг танилцуулан зөвлөмж зөвлөгөө авч ажиллаж байна.</li> </ul> <p>2. Мөн төслийн гүйцэтгэгч болон зөвлөх компаниудын ажлын явцын тайланг тогтсон хугацаанд авч хянан ЗТХЯ, АХБ-нд хүргүүлэн ажиллаж байна.</p>			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэл дундаж 70%	Зорилт 1 79%	Зорилт 2 76%	Зорилт 3 71%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ %			

**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**  
(2017 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийнагуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр,огноо, шийдвэрийн дугаар (Жич:уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	<p><b>Мандал-Багахангай чиглэлийн “Богдхан” төмөр замын төсөл:</b></p> <p>1.УИХ-ын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Богдхан” төмөр замыг барьж байгуулах ажлыг 2025 онд дуусгахаар,</p> <p>2.УИХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Богдхан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, мөн үндэсний болон олон улсын тээвэр логистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшигийн хөндий”-д холимог тээвэр логистикийн төвийг байгуулахаар,</p> <p>3.УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-т Богдхан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхээр,</p> <p>4.УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл-д тус тус тусгагдсан.</p> <p>5.Зам, тээврийн яам /хуучин нэрээр/, “Оросын төмөр замууд” НХН хооронд 2014 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан “Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн тухай хэлэлцээр”,</p> <p>7 Төслийг хэрэгжүүлэхээр Зам, тээврийн яам /хуучин нэрээр/, АХБ хооронд 2014 оны10 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан Харилцан ойлголцлын санамж бичиг,</p> <p>8.“Богдхан төмөр зам болон Улаанбаатар холимог тээврийн ложистикийн төвийг барьж байгуулах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын 110 дугаар тогтоол,</p> <p>9.Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар зам, тээврийн салбарт 2016-2020 онд хамтран ажиллах санамж бичиг,</p> <p>10. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 142 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөр.</p>
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Зам, тээврийн яам /хуучин нэрээр/, АХБ хооронд 2014 онд байгуулагдсан Харилцан ойлголцлын санамж бичигт урьдчилсан тооцоогоор төслийн нийт санхүүжилт бүхий 500 сая долларыг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр /200 сая доллар/, Засгийн газар /100 сая доллар/ болон санхүүгийн бусад байгууллагын хамтарсан санхүүжилт /200 сая доллар/-ээр санхүүжүүлэхээр тусгасан.

3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Зам, тээврийн хөгжлийн яам Нийт хугацаа: 2016-2025 Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Азийн хөгжлийн банк, "УБТЗ" ХНН			
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1.</b> Улаанбаатар хотыг тойруулан ачааны галт тэргийг аялуулах 164 км төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах,</p> <p><b>Зорилт 2.</b> Энэ чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулснаар нийслэлийг дайран өнгөрч байгаа 35 км төмөр замыг хотын зорчигч тээврийн зориулалтаар ашиглан хөнгөн галт тэрэгний үйлчилгээг нэвтрүүлэх,</p> <p><b>Зорилт 3.</b> Мөн энэ чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулснаар төмөр замаар ачаа тээвэрлэх хүчин чадал болон тээвэрлэлтийн хурдыг нэмэгдүүлж, тээврийн зардлыг бууруулна.</p>			
5	Зардал	Төсөв	743.16 сая ам.доллар		
		Үүнд:			
		Багц 1			
		Багц 2 (г.м)			
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлт			
	1-р зорилтын хүрээнд: Төмөр замын чигийн судалгаа, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	<p>Зам, тээврийн хөгжлийн яам (хуучин нэрээр), Азийн хөгжлийн банк хооронд 2014 онд төслийг хэрэгжүүлэх Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд 2015 оны 7 дугаар сард АХБ-аас "Богдхан" төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах техникийн туслалцааны 1.5 сая ам.долларыг олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>Техникийн туслалцааны хүрээнд энэхүү чиглэлийн төмөр замын чигийн судалгааны ажлыг "АйСиТиСайн Консалтинг" ХХК тэргүүтэй түншлэл 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн гэрээг байгуулан гүйцэтгэж чигийн судалгааны эцсийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ЗТХЯ-нд хүлээлгэж өгсөн.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын эхлэл болон төгсгөлийн цэгийг тодорхойлох ажлын хэсгийг ТНБД-ын 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн тушаалаар байгуулж "УБТЗ" ХНН-ийн Мандал, Багахангай өртөөнөөс салаалах эхлэл, төгсгөлийн цэгийг тодорхойлсон.</p> <p>Трассын судалгааг 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр ЗТХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн.</p>			
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарахасуудлууд)	Тус төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг АХБ-ны 2018-2020 оны Монгол улс дахь үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд тусгуулж, АХБ-ны үлдэгдэл техникийн туслалцаагаар гүйцэтгүүлэх.			
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтынажил лагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төмөр замын чигийн судалгааны ажлыг зөвлөх компани амжилттай гүйцэтгэсэн бөгөөд судалгааны ажилд төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон "УБТЗ" ХНН дэмжлэг үзүүлэн хамтарч ажилласан.			
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн)	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		100%	100%	-	-



	үнэлгээ)			
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ынүнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ	
			... %	

## ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(2017 оны жилийн эцсийн байдлаар )

№	Хөтөлбөр/Төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	<p><b>Төслийн нэр:</b> Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл.</p> <p>-Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд тус төслийг санхүүжүүлэх зээлийн гэрээг 2008 оны 5 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан. Гэрээний дугаар MON-P8. Гэрээг Монгол Улсын Их хурал 2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр соёрхон баталсан. 2008 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс Японы тал гэрээг баталснаар зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсон.</p> <p>-Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар болон Япон Улсын Мицүбиши-Чиёода хамтарсан түншлэл хооронд Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан.</p> <p>-Төслийг санхүүжүүлэх нэмэлт зээлийн гэрээг 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан. Гэрээний дугаар MON-P12. Гэрээг Монгол Улсын Их Хурлаар 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан.</p> <p>2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсон тухай Япон талаас албан ёсоор мэдэгдсэн.</p> <p>-Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар болон Япон Улсын Мицүбиши-Чиёода компаниудын хамтарсан түншлэл хооронд Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээний нэмэлт өөрчлөлт-1-ыг 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан.</p>	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилго:</p> <p>Далайд гарцгүй Монгол Улсын хувьд гадагш гарах гол хаалга болох чухал ач холбогдолтой нийслэл хотын нисэх онгоцны буудлын аюулгүй ажиллагаа, хүчин чадал, найдвартай, тав тухтай байдлыг сайжруулах үүднээс Монгол Улсын нийслэлд Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг газар зүйн ямар нэгэн хязгаарлалтаас ангид газар нутагт байгуулж, үүгээрээ Монгол Улсын эдийн засгийн цаашдын хөгжилд хувь нэмэр оруулах.</p>
2.	Санхүүжилтийн үүсвэр	<p>-Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын хөнгөлөлттэй зээл: 65.6 тэрбум Япон иен</p> <p>-Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт: 38 тэрбум төгрөг</p>
3.	Хэрэгжүүлэгч байгууллага	<p>Зам, тээврийн хөгжлийн яам</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газар</p>
	Хэрэгжүүлэх хугацаа	<p>Барилгын ажлын гэрээт хугацаа: 1290 хоног /Гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр олгосон өдөр буюу 2013 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн тооцогдсон цаг хугацаа болох 1290 хоногт багтаан Ерөнхий гүйцэтгэгч үндсэн барилга, байгууламжуудын барилга угсралтын ажлыг амжилттай хэрэгжүүлэв.</p> <p>“Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний “Нэмэлт өөрчлөлт-1” 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр байгуулагдсан.</p> <p>Эхэлсэн хугацаа-2016.10.06</p> <p>Дуусах хугацаа- 2018.08.31</p>
4.	Төслийн 2017 оны зорилтууд:	<p><b>Зорилт 1.</b>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-гээр баригдсан барилга байгууламжуудыг Захиалагчид хүлээлгэн өгөх.</p> <p>-Баригдсан барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангах</p> <p>-Улсын болон техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллах</p>

		<p>-Баталгаат засварын 1 жилийн хугацаанд илэрсэн дутагдал зөрчлийг арилгуулах,биелэлтэд хяналт тавьж ажиллах.</p> <p><b>Зорилт 2.</b>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-нийНэмэлт гэрээ 1-ийн хүрээнд баригдаж буй барилга байгууламжыг хугацаанд гүйцэтгүүлэх.</p> <p>-Дулаан гараш,Газрын үйлчилгээний албаны барилгын барилга угсралтын ажил</p> <p>-Хамгаалалтын хашаа, харуулын байрны барилга угсралтын ажил</p> <p>-Барилга байгууламжийн гадна талбай, авто зогсоолын тохижилтын ажил</p> <p>-Зүлэгжүүлэлт /Ландшафтын ажил/</p> <p>-Нэмэлт барилга байгууламжуудын гадна цахилгаан, холбооны шугамын зураг төсөл, угсралтын ажилд хяналт тавих</p> <p>-Нэмэлт барилга байгууламжуудын дулаан хангамжийн шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажилд хяналт тавих</p> <p>-Нэмэлт барилга байгууламжуудын цэвэр бохир усны шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажилд хяналт тавих</p> <p>-Захиргааны барилгыг ЗҮБ-тай холбох хүзүүвчний зураг төсөл, барилга угсралтын ажилд хяналт тавих</p> <p>-Шатахуун сумлагааны гидрант систем, агуулахын цэвэрлэгээ, туршилт, тохируулгын ажил, үндсэн болон нэмэлт зээлийн хүрээнд шатахууны байгууламжид хийгдэх барилга байгууламжийн засвар болон тоног төхөөрөмжийн угсралт, нийлүүлэлтийн ажил</p> <p>-Тооцоот ажиглалтын M-LAT системийн ажил</p> <p>-Автомашинь нэвтрэх хураамж авах цэгийн зураг төсөл, барилга угсралтын ажилд хяналт тавих</p> <p>-Хатуу хог хаягдал шатаах зуухны барилга угсралтын ажил</p> <p>-Нэмэлт зээлийн хүрээнд баригдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангах</p> <p>-Гүйцэтгэгчээс ирүүлсэн барилга угсралтын ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг шалгаж баталгаажуулах</p> <p><b>Зорилт 3.</b> Монголын Улсын төсвийн санхүүжилтээр баригдах Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга, Захиргааны барилга болон Аэродромын засвар үйлчилгээний барилга байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах.</p> <p><b>Зорилт 4.</b> Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дотоод ажлуудыг хэрэгжүүлэх.</p>			
5.	Зардал	Төсөв	Нийт төсөв: Зээлийн хөрөнгөөр 65.6 тэрбум иен, дотоодын хөрөнгө оруулалтаар 38 тэрбум төгрөг		
			<b>Төсөв /2009 он/</b>	<b>Гүйцэтгэл /2009 он/</b>	<b>Хувь</b>
		MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/	233.1 сая иен	288.1 сая иен	100.0%
		Монголын Засгийн газрын санхүүжилт	-	-	
			<b>Төсөв /2010 он/</b>	<b>Гүйцэтгэл /2010 он/</b>	<b>Хувь</b>
		MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/	450.7 сая иен	590.1 сая иен	100.0%
		Монголын Засгийн газрын санхүүжилт	-	-	
		<b>Үүнд:</b>	<b>Төсөв /2011 он/</b>	<b>Гүйцэтгэл /2011 он/</b>	<b>Хувь</b>
		MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/	110.8 сая иен	273.1 сая иен	100.0%
		Монголын Засгийн газрын санхүүжилт	-	-	
<b>Үүнд:</b>	<b>Төсөв /2012 он/</b>	<b>Гүйцэтгэл /2012 он/</b>	<b>Хувь</b>		

	MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө	657.6 сая иен	115.8 сая иен	16%
	Монголын Засгийн газрын санхүүжилт	22.3 тэрбум төгрөг	1.6 тэрбум төгрөг	7.2%
	<b>Үүнд:</b>	<b>Төсөв /2013 он/</b>	<b>Гүйцэтгэл /2013 он/</b>	<b>Хувь</b>
	MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/	1.9 тэрбум иен	11.4 тэрбум иен	100.0%
	Монголын Засгийн газрын санхүүжилт	28.1 тэрбум төгрөг	26.4 тэрбум төгрөг	93.9%
	<b>Үүнд:</b>	<b>Төсөв /2014 он/</b>	<b>Гүйцэтгэл /2014 он/</b>	<b>Хувь</b>
	MON-P8 төсөл /зээлийн хөрөнгө/	6.8 тэрбум иен	8.2 тэрбум иен	100%
	Монголын Засгийн газрын санхүүжилт	9 тэрбум төгрөг	0.14 тэрбум төгрөг	1.6%
	<b>Үүнд:</b>	<b>Төсөв /2015 он/</b>	<b>Гүйцэтгэл /2015 он/</b>	<b>Хувь</b>
	MON-P8, MON-P12 төсөл /зээлийн хөрөнгө/	4.6 тэрбум иен	4.4 тэрбум иен	95.6%
	Монголын Засгийн газрын санхүүжилт	38 тэрбум төгрөг	0 тэрбум төгрөг	0%
	<b>Үүнд:</b>	<b>Төсөв /2016 он/</b>	<b>Гүйцэтгэл /2016 он/</b>	<b>Хувь</b>
	MON-P8, MON-P12 төсөл /зээлийн хөрөнгө/	3.7 тэрбум иен	14.9 тэрбум иен	100%
	Монголын Засгийн газрын санхүүжилт	24.5 тэрбум төгрөг	4.4 тэрбум төгрөг	17,95%
	<b>Үүнд:</b>	<b>Төсөв /2017 он/</b>	<b>Гүйцэтгэл /2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар/</b>	<b>Хувь</b>
	MON-P8, MON-P12 төсөл /зээлийн хөрөнгө/	17.9 тэрбум иен	13.2 тэрбум иен	73.2%
	Монголын Засгийн газрын санхүүжилт	17.4 тэрбум төгрөг	6.7 тэрбум төгрөг	79.06%
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт			
	<b>1-р зорилтын хүрээнд:</b>	Төслийн үндсэн гэрээний барилга, байгууламжуудын барилгын ажлыг бүрэн дуусгаж 2017 оны 01 дүгээр сард Улсын комисс ажиллуулан, захиалагч талд хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй уялдуулан Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани, Ерөнхий гүйцэтгэгч болон Төслийн Ерөнхий туслан гүйцэтгэгч компаниуд өвлийн улиралд талбай дээр байрлан ажилласан болно. Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/ болон Япон Улсын “Мицүбиши-Чиёода хамтарсан түншлэл хооронд 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал барих барилгын ажлын гэрээ” MONP8-ын дагуу Ерөнхий гүйцэтгэгч төслийг төлөвлөсөн цаг хугацаа болох 1290 хоногт багтаан амжилттай хэрэгжүүлж, Улсын комисс болон Иргэний нисэхийн ерөнхий газраас өгсөн 01/293 тоот зөвшөөрлийн дагуу Зөвлөх компани 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр “Ажил хүлээн авах гэрчилгээ”-г гаргасан ба тус гэрчилгээнд дурдсан барилга байгууламж, дагалдах тоног төхөөрөмжийг 2017 оны 01 дүгээр сарын 10-ны		

		<p>өдрөөр тооцож Захиалагчид шилжүүлсэн болно. Гүйцэтгэгчид “Ажил хүлээн авах гэрчилгээ”-г олгосноор “Чанарын баталгаат хугацаа” эхлэх ба 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэлх нэг жилийн хугацаанд Улсын комиссын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу гишүүдийн саналын хуудсаар баталгаажсан нийт 1278 үүрэг даалгаврыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.</p> <p>Захиалагч талд шилжүүлээд буй Цахилгаан хангамжийн 10кВ-ын Үндсэн дэд өртөө, 10/0.4кВ-ын салбар 8 ком дэд станцууд болон барилга байгууламжуудын дулаан, цэвэр, бохир усны байгууламжууд, агаар сэлгэлтийн систем, сантехникийн инженерийн шугам сүлжээний 24 цагийн ашиглалт, шуурхай ажиллагааг УБХОУШНБ-ын Ашиглалтын өмнөх захиргааны алба 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн хариуцан ажиллаж байна.</p> <p>Барилгын ажлын чанарын хяналтыг төслийн “Чанарын менежментийн тогтолцоо”-ны дагуу гүйцэтгэж байна. Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани чанарын хөндлөнгийн аудитыг тогтмол гүйцэтгэж, Ерөнхий гүйцэтгэгч, Ерөнхий туслан гүйцэтгэгчтэй чанарын баталгаажуулалтын асуудлаар хуваарийн дагуу уулзалтуудыг хийж санал солилцон ажлыг дүгнэж, холбогдох зөвлөмж зааварчилгаа өгч байна. Барилгын материалд лабораторийн шинжилгээ хийлгэн байна.</p> <p>Захиалагч талд шилжүүлээд буй Үндсэн болон түр барилга байгууламжийн ашиглалт, харуул хамгаалалтыг 2017 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал ерөнхий гүйцэтгэгч “Мицүбиши-Чиёода” хамтарсан түншлэл хариуцан ажилласан ба гэрээний дагуу 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөр Төслийн үндсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн эрсдэлийн асуудал Захиалагч талд шилжсэн болно.</p> <p>Барилгын талбайн харуул хамгаалалт “Чингис хаан Олон улсын нисэх буудал”-ын Аюулгүй байдал, хамгаалалтын албанд 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр шилжсэн ба тайлант хугацаанд талбайн өдөр тутмын аюулгүй байдлын үйл ажиллагаа хэвийн явагдаж осол, зөрчилгүй ажиллав.</p> <p>Дулааны станцын галлагаанд зуны улирлын “0 зогсолт” хийх, системийн технологи, үйл ажиллагааг үе шаттай зогсоох горимд шилжүүлэн системийг консервацлах, нрэх өвлийн улиралд хэвийн ажиллуулах барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэж ажил хийгдэж дууслаа.</p> <p><u>Үндсэн гэрээний хүрээнд баригдсан барилга, байгууламжуудыг ашиглалтад оруулах, улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангах хүрээнд:</u></p> <p>Төслийн үндсэн барилга байгууламжийг барих, тоног төхөөрөмжийг суурилуулж угсрах ажлууд дууссан бөгөөд Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани, Ерөнхий гүйцэтгэгч болон Ерөнхий туслан гүйцэтгэгч компаниуд хамтран 2016 оны 04 дүгээр улиралд техникийн үзлэг хийж нэгдсэн дүгнэлт гарган холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн шинэ нисэх буудлыг ашиглалтад хүлээн авах асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлж ажилласан.</p> <p>Улмаар Монгол Улсын хууль журмын дагуу барилга, байгууламжийг ашиглагч байгууллагад шилжүүлэхэд Улсын комисс ажиллаж хяналт шалгалт хийсэн байх шаардлагатай гэж заасны дагуу барилгын ажлын Үндсэн</p>
--	--	---

		<p>гэрээний хүрээнд баригдсан барилга, байгууламжуудыг Улсын комисст хүлээлгэн өгөх ажлыг хангаж ажиллаа.</p> <p>Улсын комиссын бэлтгэл ажлын хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/892 тушаалаар байгуулагдсан Иргэний нисэхийн ерөнхий газрын 28 гишүүн, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани, Ерөнхий гүйцэтгэгч, ерөнхий туслан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудаас бүрдсэн 104 хүний бүрэлдэхүүнтэй техникийн комисс Төслийн талбай дээр 2016 оны 12 дугаар сарын 21-нээс 28-ны өдрийн хооронд ажилласан.</p> <p>2016 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Техникийн комиссын дүгнэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд урьдчилан танилцуулан Ерөнхий гүйцэтгэгчтэй хийсэн үндсэн гэрээний хүрээнд баригдсан барилга байгууламжуудыг Улсын комиссын үзлэгт хамруулж ашиглалтад оруулах шийдвэр гаргуулах хүсэлтийг Зам, тээврийн хөгжлийн сайдад уламжилсан юм.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 123 тоот тушаалаар Улсын комисст ажиллах холбогдох албаны удирдлага, инженер техникийн ажилчид, мэргэжилтнүүдээс бүрдсэн 56 гишүүн томилогдсон ба 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 04 дүгээр тушаалаар Улсын комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж 26 гишүүн нэмж томилсон. Үүний дагуу 2017 оны 01 дүгээр сарын 02-ноос 18-ны өдрийн хооронд Улсын комиссын бүрэлдэхүүн 11 чиглэлээр ажлын хэсэгт хуваагдан төслийн талбай дээр ажиллаж, барилгын ажил гүйцэтгэсэн техникийн бичиг баримтын бүрдэл, зураг төсөл, барилгын ажлын гүйцэтгэлд үзлэг шалгалт хийсэн. 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Улсын комиссын ажлын тайланг Засгийн газарт танилцуулсан.</p> <p>Улсын комиссын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Чанарын баталгаат хугацаанд үе шаттайгаар төлөвлөгөө гарган арилгах буюу зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллахаар болсон юм.</p> <p><u>Улсын комисс, техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт:</u></p> <p>Улсын комиссоос өгсөн нийт 1278 үүрэг даалгаврын 792 нь Ерөнхий туслан гүйцэтгэгчийн зардлаар засаж залруулах ажлууд ба 94.57% нь засагдаж дууссан бөгөөд үүнээс 429 ажлыг Зөвлөх компани болон Ашиглалтын өмнөх захиргааны албаны инженерүүд шалгаж баталгаажуулсан ба 320 ажил хянагдаж баталгаажих шатандаа явж байна. Эдгээр ажлуудад гадна хаалганы тоноглолыг бүрэн гүйцэд суурилуулах, зай, завсрыг битүүлэх, чигжээс хийж, заслыг гүйцээх, дотор ханын хялгасан хагарал, цууралтыг засварлах, шилэн кабелийг цэгцэлж зориулалтын тавиурт бэхлэх арга хэмжээ авах, цонхны угсралтын ажил, барилгуудын өрөөнүүдийн хана, шал, хаалга, унтраалга, розетканы хүрээний гэмтлийг засах, будгийн өнгө ялгааг арилгах, жигд болгох, таазны хүрээ болон гипсэн хавтангийн хооронд гарсан зайг битүүлэх, тоног төхөөрөмжийн сууриуд, шалны завсрын шавардлагыг тэгш болгож, зүлгэж будах, гадна камер, гарах товч, карт уншигч болон дамжуулах хайрцагуудыг суулгаж дуусгах, алсын удирдлагын хяналтын системийг холбон ажилд оруулах, хөөрч буух зурвасын тэлэлтийн заадсуудыг битүүмжлэх, ажлын акт, гүйцэтгэлийн зураг, улаан дэвтэр хөтлөлтийг</p>
--	--	---

		<p>бүрэн болгох, туршилт тохируулгыг хийж дуусгах гэх мэт ажлууд орсон болно.</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газар болон “Мицүбиши-Чиёода” хамтарсан түншлэлийн хооронд байгуулсан бүтээн байгуулалтын гэрээнд заасны дагуу ажлын тоо хэмжээ болон зураг төсөлд тусгагдаагүй ажлыг захиалагчийн хүсэлтээр хийх тохиолдолд нэмэлт зардлын асуудал үүсэх юм. 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Улсын комиссын үүрэг даалгаварт Зөвлөх компанийн хариуцсан 214 ажил байгаагаас 115 нь нэмэлт зардал шаардагдах ажлууд байгаа ба үүнээс 63-д нь гүйцэтгэгчээс үнийн саналыг авч, 8-ыг хянаж баталгаажуулсны дагуу уг ажлуудыг гүйцэтгэж байгаа болно. Харин зураг төсөл, төлөвлөлттэй холбогдолтой 134 ажлын 88-д нь Зөвлөх компани тайлбар хийж Төсөл хэрэгжүүлэх нэгжид албан бичгээр ирүүлэн хаах хүсэлт гаргасныг Ашиглалтын өмнөх захиргааны албанд уламжлаад байна. <b>100%</b></p>
	<p><b>2-р зорилтын хүрээнд:</b></p>	<p>Төслийн нэмэлт зээл /MON-P12/-ийн хөрөнгөөр санхүүжигдэх нэмэлт ажлуудыг Ерөнхий гүйцэтгэгч “Мицүбиши-Чиёода” хамтарсан түншлэлийн гэрээнд нэмж оруулахыг зөвшөөрч буй тухай байр сууриа Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ Зам, тээврийн яаманд 2015 оны JICA(MG) 01-04001 тоот албан бичгээр мэдэгдсэн байв. Үүний дагуу уг асуудлыг Төслийн удирдах хорооны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд хуралдаанаар нэмэлт ажлуудыг Ерөнхий гүйцэтгэгчийн гэрээнд нэмж оруулан гүйцэтгүүлэхийг дэмжиж нэмэлт ажлуудыг “Мицүбиши-Чиёода” хамтарсан түншлэлийн гэрээнд нэмэлтээр оруулах асуудлыг Зам, тээврийн яаманд /хуучин нэрээр/ тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмж гарсан болно.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж нэмэлт ажлуудын Ажлын даалгаврыг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн яамаар хянуулан Зам, тээврийн хөгжлийн сайдаар батлуулсан болно. Тус Ажлын даалгаврыг үндэслэн Гүйцэтгэгчийн Гэрээний нэмэлт өөрчлөлт №1-ийн төслийг Зөвлөх компани боловсруулсныг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичиг хянан 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр талууд гарын үсэг зурж албан ёсоор гэрээнд өөрчлөлт оруулав.</p> <p>Төслийн нэмэлт барилга, байгууламжуудын Ерөнхий туслан гүйцэтгэгч “М-Си-Эс Проперти” ХХК нь 2017 оны 02 дугаар сард төслийн талбай дахь түр оффисын барилгын ажлаа дуусгаж, 03 дугаар сарын 06-ны өдрөөс төслийн талбайд байршин ажиллаж байна.</p> <p>Долоо хоногт дунджаар төслийн нэмэлт ажлуудыг гүйцэтгэхээр 202 гадаад, дотоодын ажилтан, 20 машин механизм ажиллав. 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэлийг <b>99.03%</b>-д хүргэж төлөвлөгөөт гүйцэтгэлийг 0.97%-иар дутуу биелүүлэв..</p> <p>Нэмэлт ажлын гэрээний Гүйцэтгэгч “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2017”-г “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” болон холбогдох журмын дагуу боловсруулж Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамаар батлуулан ажиллаж байна</p> <p>Барилгын ажлын чанарын хяналтыг төслийн “Чанарын менежментийн тогтолцоо”-ны дагуу гүйцэтгэж байна. Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани чанарын хөндлөнгийн аудитыг тогтмол гүйцэтгэж, Ерөнхий гүйцэтгэгч, Ерөнхий</p>

		<p>туслан гүйцэтгэгчтэй чанарын баталгаажуулалтын асуудлаар хуваарийн дагуу уулзалтуудыг хийж санал солилцон ажлыг дүгнэж, холбогдох зөвлөмж зааварчилгаа өгч байна. Барилгын материалд лабораторийн шинжилгээ хийлгэн ашиглаж байна.</p> <p>Газрын үйлчилгээний машин механизмын барилга – 99.1%  Автомашины дулаан зогсоолын барилга – 98.2%  Хатуу хог хаягдал шатаах цэг – 99.7%  Автомашины төлбөр хураах цэг – 92.5%  Зорчигч үйлчилгээний барилгыг захиргааны барилгатай холбох хонгил – 99.3%  Нисэхийн шалган нэвтрүүлэх байр 1,2,3 – 99.8%  Харуулын байр 1,2,3,4 – 99.7%</p> <p><b>Аэродромын тооцоот ажиглалтын систем /MLAT/-ийн</b> суурилуулалт, туршилт тохируулгын ажлын гүйцэтгэл талбайн туршилтыг амжилттай хийж, ИНЕГ-аас холбогдох зөвшөөрлийг авч, "Ажил хүлээн авах гэрчилгээ"-г олгож ажиллав.</p> <p>27 нэр төрөл бүхий 116 ширхэг <b>Газрын тусгай үйлчилгээний тоног төхөөрөмжийг</b> Гүйцэтгэгч төслийн талбайд нийлүүлээд байгаа бөгөөд үүнээс 106 тоног төхөөрөмжид "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажлын гэрээ"-ний 10.1 дүгээр заалт [Ажил болон ажлын хэсгийг хүлээн авах]-ын дагуу төслийн Зөвлөх компани "Азүсса Сэксэй-Ориентал Консалтантс Глобал" хамтарсан түншлэлээс "Ажил хүлээн авах гэрчилгээ"-г гаргасан юм.</p> <p>Нэмэлт зээл /MON-P12/-ийн хөрөнгөөр санхүүжих ажлын хүрээнд "Мицүбиши-Чиёода" хамтарсан <b>түншлэлээс нисэх буудлын барилга байгууламжийн инженерийн гадна шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчдийг</b> сонгон шалгаруулж, 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдөр угсралтын ажлыг төслийн талбайд эхлүүлээд байна. Шугам сүлжээний угсралтын ажил 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 79.2%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд уг ажлыг 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <p><b>Нэмэлт барилга, байгууламжийн инженерийн шугам сүлжээний ажлын явц:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Захиргааны барилга – 99.7%</li> <li>• Автомашины дулаан зогсоол – 70.5%</li> <li>• Газрын үйлчилгээний машин механизмын барилга, дулаан гараж - 74.5%</li> <li>• Аэрэдромын үйлчилгээний барилга – 99.3%</li> <li>• Каргоны барилга-99.0%</li> <li>• Бусад барилгууд – 92.1%</li> <li>• Цэвэр, бохир усны барилга, байгууламж -39.6%</li> </ul> <p>Шинэ нисэх буудлын хамгаалалтын бүс дэх <b>зүлэгжүүлэлтийн ажил</b> 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдөр эхэлсэн ба 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэлийг <b>88.3%</b>-д хүргэсэн байна. Нийт 75 гаталбайд автоматжуулсан болон зөөврийн усалгаа хийгдэж, зүлэгний ургалтын хэмжээ 15-19см, үндэсний ургалтын хэмжээ 4-9см тус тус байгаа бөгөөд усалгаа, бактерийн бордоо цацах, чулуу түүх болон гадаргуун тэгшлэх ажлуудыг хийв. Төлөвлөгөөний дагуу 2018 онд зүлэгжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх болно. <b>94.6 %</b></p>
	<b>3-р зорилтын хүрээнд:</b>	<u>Захиргааны барилга, Аэродромын засвар үйлчилгээний барилга, Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга</u>



		<p>Эдгээр барилгуудын гүйцэтгэгчээр “Ви Эйч энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэл Зам, тээврийн яамтай /хуучин нэрээр/ 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 113/14 тоот гэрээ, 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 29 тоот нэмэлт гэрээг тус тус байгуулсан боловч 2017 оны төлөвлөгөөт ажил цаг хугацаандаа дуусаагүй тул 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт гэрээг байгуулсан.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж, дээрх барилгуудын Зураг төсөл зохиогчийн хяналт хийж буй “Говь Трэвэл” ХХК, барилгын явцын хяналт хийж буй Барилгын хөгжлийн төв нар барилгын ажилд хяналт тавьж гэрээний дүгнэлт гарган Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн яамнаас гүйцэтгэгчийн гэрээг дүгнэх ажлын хэсэг томилон холбогдох байгууллагуудтай хамтарсан хурлыг төслийн талбай дээр 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 11 дүгээр сарын 29-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд тус тус хуралдаж Ви Эйч энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэлийн 2017 оны ажлыг гүйцэтгэлийг дүгнэж, гэрээг 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгах тухай шийдвэр гаргасан.</p> <p>Захиргааны барилгыг 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр, Аэродромын засвар үйлчилгээний барилга болон Ачаа шуудан, тээврийн үйлчилгээний барилга угсралтын ажлыг 2018 оны 07 дугаар сарын 21-нд тус тус гүйцэтгэж, Улсын комисстхүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн.</p> <p>Дээрх 3 барилгын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 78,9%-тай байна. Үүнд:</p> <p>А. Аэродромын үйлчилгээний барилгын ажил – 74.67%</p> <p>Б. Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын ажил – 74.71%</p> <p>В. Захиргааны барилгын ажил – 91.77 %</p> <p><b>78.9 %</b></p>
	<p><b><u>4-р зорилтын хүрээнд:</u></b></p>	<p>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 7 хоног тутам шуурхай хурал хийж, ажлын явц байдлыг хэлэлцэж цаг хугацаа алдахгүй шийдвэрлэх асуудлын явц байдлыг дүгнэж, тулгамдсан ажлуудыг тодорхойлон ажиллаж байна.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж, Ашиглалтын өмнөх захиргааны алба, Зөвлөх, Гүйцэтгэгч, Ерөнхий туслан гүйцэтгэгч талууд хамтран Техникийн комисс, Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон чанарын баталгаат хугацааны үед буюу ашиглалтын явцад илэрсэн алдаа дутагдлыг засварлах ажлын явцын талаар тогтмол хэлэлцэж байна. Ээлжит хурал зохион байгуулагдаж, шийдвэрлэх асуудлын явц байдлыг дүгнэн, тулгамдсан ажлуудыг тодорхойлон ажиллаж.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх компани, Ерөнхий гүйцэтгэгч, Ерөнхий туслан гүйцэтгэгчийн 7 хоног тутам хамтарсан уулзалтыг төслийн талбай дахь хурлын танхимд хийж Гүйцэтгэгчийн өнгөрсөн 7 хоногийн ажлын тайланг хэлэлцэж дүгнэн холбогдох чиглэл өгч ажиллав.</p> <p>Монгол 3 барилгуудын гүйцэтгэгч “Ви Эйч энд Би” ХХК болон Захиалагчийн хяналт хийж буй Барилгын хөгжлийн төвтэй 7 хоног тутам барилгын явцын хурал хийж байна.</p> <p>Төслийн хүрээнд ашиглах бараа, материал, тоног төхөөрөмжүүдийг ажлын талбайд татан авах ажил хэвийн явагдаж байна. Эдгээрээс импортоор оруулах бараа, материал, тоног төхөөрөмжийг Монгол Улсын гаалийн татвар хураамжаас чөлөөлүүлэн хугацаанд нь цаг алдалгүй</p>

		хилээр нэвтрүүлэх талаар холбогдох яам, газруудтай уялдаатай ажиллаж, ажлын талбайд буусан материал, тоног төхөөрөмжийг төлөвлөгөөтэй уялдуулан ажлын талбайд татан авчрах ажил болон тоо хэмжээнд хяналт тавьж ажилладаг болно. Импортоор оруулах материал, тоног төхөөрөмжийн жагсаалт, холбогдох баримт бичгүүдийг төслийн Зөвлөх компанийн хамт хянаж баталгаажуулан Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж ажиллаж байна. <b>100%</b>					
7.	Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/	<p>Төслийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажлууд төлөвлөгөөний дагуу хэвийн хэрэгжиж байна.</p> <p>2017 онд Төслийн нэмэлт барилгуудын Ерөнхий туслан гүйцэтгэгчээр үндэсний компани шалгарсан нь дотоодын мэргэжлийн ажиллах хүчнээр бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгүүлж, төсөл дээр ажиллаж буй гадаадын болон дотоодын туршлагатай инженерүүдээс ихийг суралцах, дадлага туршлагаа нэмэгдүүлэх, төслийн бичиг баримтыг олон улсад мөрдөгдөг заавар, зөвлөмжийн дагуу боловсруулж ажиллах боломжоор хангагдсан нь ололт байлаа.</p> <p>Энэхүү төсөл нь Олон улсын гэрээ болон Фидик буюу олон улсын зөвлөх инженерүүдийн холбооны загвар гэрээний дагуу хэрэгжиж, гэрээний зарим заалтууд Монгол Улсын хууль тогтоомжтой зөрүүтэй байдал үүсэх, энэ тохиолдолд зөрчил үүсч, ажлыг явуулахад зарим талаар ажилд саад учрах тохиолдол гарч байлаа. Тухайлбал, Гэрээ байгуулахын өмнө Тендерийн үе шатанд барилгын ажлын гадаад гүйцэтгэгч нь тухайн улс орондоо тусгай зөвшөөрөл авсан байвал түүнийг дүйцүүлэн ашиглах талаар албан ёсоор тохиролцсоны дагуу өнөөдөр төслийн Ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нар өөрийн оронд олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу ажиллаж байгаа болно. Гэвч Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төлөвлөгөөт хяналт шалгалтаар Монгол Улсад барилгын тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулах албан шаардлагыг биелүүлж ажиллахыг шаарддаг болно.</p> <p>Шинэ нисэх буудалд холбогдох хурдны авто замын ажил энэ онд эрчимтэй хийгдэж шинэ нисэх буудал ашиглалтад оруулах үеэр хурдны авто замтай байхаар төлөвлөн ажиллаж байгаа нь төслийн хэрэгжилтэд ихээхэн хувь нэмэр болж байна.</p> <p>Сонгино 220/110/35 кВ-ын 2х125 МВа чадалтай Дэд станцын барилгын ажлууд хоцорч байгаа нь төслийн барилгын ажлыг хугацаанд нь дуусгах, Нисэх онгоцны шинэ буудлыг хугацаанд нь ашиглалтад оруулахад сөргөөр нөлөөлж болзошгүй тул уг ажлыг эрчимжүүлэх талаар холбогдох яам, газрууд анхаарах шаардлагатай байна.</p>					
8.	Төслийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэгч талуудын хоорондын хамтын ажиллагаа сайн байна.					
9.	Төслийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж %	Зорилтууд				
		100%	Зорилтын тоо	1	2	3	4
			4	100.0	94.6	78.9	100.0
10	Төсөл, хөтөлбөрийн нэгдсэн (ЗГХЭГ-ын) үнэлгээ						

